



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠑ оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/1536

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 156 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 22 нэр төрлийн нийт 10,534,108.83 (арван сая таван зуун гучин дөрвөн мянга нэг зуун найман төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 156 дугаар цэцэрлэг (Ц.Сарантуяа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 950,000.00 (есөн зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, 20 нэр төрлийн татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн нийт 9,584,108.83 (есөн сая таван зуун наян дөрвөн мянга нэг зуун найман төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 156 дугаар цэцэрлэг (Ц.Сарантуяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюунтуул* В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн АХБ дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр : Нийслэлийн хүүхдийн 156 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	ҮХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Том хөргөгч	5	ш	2	246,408.30	492,816.60	492,816.60	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
2	Зееврийн кварц	3	ш	1	84,000.00	84,000.00	84,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
3	Будаа агшаагч	3	ш	1	39,060.00	39,060.00	39,060.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
4	Компьютер могол	10	ш	1	176,550.00	176,550.00	176,550.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
5	Процессор	7	ш	1	240,000.00	240,000.00	240,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
6	Нетбукк Dell	6	ш	2	1,749,500.00	3,499,000.00	3,499,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
7	Жин хэмжүүр хил	10	ш	1	50,400.00	50,400.00	50,400.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
					Тоног төхөөрөмжийн дун	4,581,826.60	4,581,826.60						
2.Тавилга эд хогшил													
8	Гал тогооны ком шүүгээ	8	ш	3	79,915.71	239,747.13	239,747.13	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
9	Хувцасны шүүгээ бор	8	ш	3	78,000.00	234,000.00	234,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
10	Багш сандал хар	8	ш	10	4,950.00	49,500.00	49,500.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
11	Хүүхдийн ширээ ногоон	8	ш	2	51,996.70	103,993.40	103,993.40	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
12	Багш ширээ саарал	8	ш	10	28,050.00	280,500.00	280,500.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
13	Сандал хар чарган	4	ш	10	77,563.89	775,638.90	775,638.90	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах

